



СҮХБААТАР АЙМГИЙН ХУДАЛДАН  
АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2024 оны 03 сарын 28 өдөр

Дугаар 18/Б

Баруун-Урт сум

Ёс зүйн дэд хороо байгуулах  
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.2, аймгийн Засаг даргын 2023 оны "Худалдан авах ажиллагааны газар шинээр байгуулах тухай" А/664 дүгээр захирамжийн нэгдүгээр хавсралтаар баталсан "Худалдан авах ажиллагааны газрын дүрэм"-ийн 2.3, Газрын даргын 2024 оны А/04 дүгээр тушаалаар баталсан "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 2.3.11 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Худалдан авах ажиллагааны газрын Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнийг 3 гишүүнтэй байхаар тогтоож, газрын албан хаагчдын санал хураалтын дүнг үндэслэн Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Дэд хорооны даргыг хорооны хурлаар хэлэлцэж, сонгохыг дэд хорооны гишүүдэд даалгасугай.

3.Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар гаргасан гомдол, мэдээллийг хуульд заасан харьяаллын дагуу шалган шийдвэрлэж, ажлын тайлан, мэдээг холбогдох газарт хүргүүлж байхыг Ёс зүйн дэд хороонд үүрэг болгосугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль эрх зүй, дотоод ажил, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн (Б.Галсанжамц)-д үүрэг болгосугай.

ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ө.ТАЙВАНСАНАА

2224010041